

Хүнс, хөдөө аж ахуйн газар
2015 оны 03 дугаар сард зохион байгуулсан ажлын тайлан

Нэг.Удирдлага зохион байгуулалтын талаар

2015 оны 3-р сарын 05-ны өдрөөс эхлэн мэргэжилтэн Д.Амарсоёлоос хүний нөөцийн ажлыг Г.Тунгалаг хариуцуулах шийдвэр гарч, ажлыг хүлээлцэх ажил явагдаж байна. Ажилд авах 1, ажил шилжүүлэх 1, ажил хүлээлцэх 2, арга хэмжээ авах 5, ажлаас халах 1 тушаал төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлийн аудит орсонтой холбогдуулан 5 акт, 6 шаардлага, зөвлөмж ирүүлсний дагуу холбогдох арга хэмжээ авч ажиллаж байна.

Салбарын хүрээнд

Мал аж ахуй салбар: Мал төллөлт, төл бойжилт, Том малын зүй бусын хорогдлын мэдээг Аймгийн Хөгжлийн бодлогын хэлтэс болон УМЭҮГ, ХХААЯ-ны МААБХЗГ-т тус тус хүргүүлэн ажиллаж байна. 2015 оны 3 дүгээр сарын 18-ны байдлаар Оны эхний хээлтэгч малын 14 буюу 20,9 мянган эх мал төллөж 99,5 хувь бойжиж байна. Том малын зүй бусын хорогдол 0,1 хувь буюу 0.32 мянган толгой, хээлтэгч малын 0,09 хувь буюу 0,13 мянган толгой мал хорогдсон дүнтэй байна.

Дархан сумын 2,3 дугаар багийн Захиргаатай хамтран Ширээ нуруу, Хавцал, Баяндаваа орчмын 24 малчин өрхийн хаваржилт, төл бойжилттой танилцан байгууллага, аж ахуйн нэгжийн хандив тусламж элгэвч, нэмнээ, лаа чүдэнз, бээлий, гурилыг малчдад хүргэлээ. Мөн малчдыг эрүүл мэндийн үзлэгт хамрууллаа.

Аймгийн өвөлжилтийн бэлтгэл хангуулах комиссийн шийдвэрээр нөөцөнд хадгалагдаж байсан 56 тонн буюу 2800 боодол өвсийг сумдын хүсэлтээр 1 боодлыг нь 1500 төгрөгөөр бодож олгох ажлыг зохион байгуулж дуусаад байна.

Зөгий эрхлэгчдийн судалгааг шинэчилэн гаргаж ХХААЯаманд хүргүүлэв.

Хонгор сумаас зохион байгуулсан “Малчдын зөвлөгөөн”-нд оролцож цаг үеийн мэдээлэл болон “Монгол мал” Үндэсний хөтөлбөр, “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”-ын хэрэгжилт “Малын удмын сангийн Үндэсний цогцолбор”-ын ажлын явцын талаар малчдад мэдээлэл хийж оролцов.

Газар тариалангийн салбар

Үр тарианы хувьд 1739,1 тн үр шаардлагатай байгаа бөгөөд аж ахуй нэгжүүд 1183 тн үрийг нөөцөлж, дутагдаж байгаа 852.4 тн үрийн захиалгыг аж ахуйн нэгж, иргэн бүрээр гаргаж, нэгтгэн, ХХААЯаманд захиалаад байна.

Тариалан эрхлэлтийг дэмжих сан өнгөрсөн онд буудайны үр хангалттай хэмжээгээр нөөцөлсөн боловч өнөөдрийн байдлаар ямар үнээр, ямар нөхцлөөр үр олгох шийдвэр нь гараагүй байна.

Тариалалт, уринш боловсруулалтанд шаардагдах шатах тослох материалын захиалгыг тариалан бүхий аж ахуйн нэгж, иргэдээс хүлээн авч, нийт 594,8 тн шатахууны тооцоог гаргаж ХХААЯ-аманд захиалаад байна.

УГТСЭШХүрээлэн, ХААИС-тай хамтран нэрт эрдэмтэн, сурган хүмүүжүүлэгч шинжлэх ухааны доктор, профессор Д.Цэрмаагийн нэрэмжит шилдэг бүтээл шалгаруулах уралдааны оюутан залуучуудын дунд амжилттай зохион байгууллаа.

ХХААЯ-наас 3 сарын 9-13-ны хооронд зохион байгуулсан инженер, механикчдийн мэргэжил дээшлүүлэх давтан сургалтанд үр тарианы үйлдвэрлэл эрхлэгч 4 аж ахуйн нэгжийг хамрууллаа.

Ерөнхий сайдын 2015 оны 73 дугаар захирамжийн дагуу гурлын үйлдвэрүүд болон газар тариалангийн аж ахуйн нэгжүүдийн агуулахад хадгалагдаж байгаа хүнсний буудайн хэмжээ цавуулгийг тогтоох ажлыг МХГ, монголын тариаланчдын холбоо, үр тариа үйлдвэрлэгчдийн холбооноос оролцсон ажлын хэсэг томилогдон 5 гурлын үйлдвэр, 1 аж ахуйн нэгжид хадгалагдаж буй 44314.3 тонн буудайнаас дээж авч цавуулгыг тогтоон дүн, актыг МХЕГазар болон ХХААЯ-нд хүргүүлсэн байна.

МҮХАҮТ-аас үйлдвэржилтийн газрын зургийг шинэчлэх, орон нутагт ЖДҮ-ийг дэмжих зорилгоор 3 сарын 09-нд зохион байгуулсан “Үндэсний хэлэлцүүлэг”-т оролцон ХАА-н салбарын үйлдвэржилтийн талаар санал бодлоо тусгуулан ажиллаа.

Хүнсний ногооны хувьд үрслэг бойжуулах ажил хаврын хавсаргатай өрсөлдөн эхлэж байна.

Аймгийн “Тариаланчдын зөвлөгөөн”-г 4-р сарын эхний 10 хоногт багтаан зохион байгуулахаар төлөвлөгөө боловсруулан, бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

Хүнсний үйлдвэрлэлийн салбар

Үйл ажиллагаа явуулж байгаа гурилын үйлдвэрүүдээс “Улаанбуудайн үлдэгдэл, гурил үйлдвэрлэлт, борлуулалтын үнийн судалгаа”-г тогтмол авч, ХХААЯ-д хүргүүлж байна. 2015.02.15-ны байдлаар үлдэгдэл буудай 56,4 мян.тн, гурил 4,3 мян.тн, үйлдвэрлэлт 5,3 мян.тн, борлуулалт 4,4 мян.тн, 1 кг дээд гурил БГ055-980 төг, 1-р гурил БГ085 -770-780 төг, 2-р гурил БГ115 -400-510 төг, хивэгний үнэ 370-380 төгрөгний үнэтэй байна.

Хүнсний үйлдвэрийн судалгааг мах махан бүтээгдэхүүн, сүү, сүүн бүтээгдэхүүн, гурил, талх, гурилан бүтээгдэхүүн, ус, хүнсний ногоо боловсруулах, зөгийн бал, өндөг үйлдвэрлэл, бусад гэсэн чиглэл тус бүрээр ирүүлсэн маягтын дагуу гаргаж, ХХААЯ-ны ХҮБХЗГ, ХШҮДАГ, аймгийн ХБХ-т тус тус хүргүүлсэн байна.

Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгтэй хамтран ажиллаж, Евро фүүдс супермаркет худалдааны газрын ажилчдад сургалт хийхээр бэлтгэл хангаад байна.

СӨБ болон ЕБС-ийн 1-5-р ангийн хүүхдийн хүнсний бүтээгдэхүүний бодит хэрэглээ, үнэ, мах, махан бүтээгдэхүүн, сүү, сүүн бүтээгдэхүүн, гурил, төмс, хүнсний ногооны техникийн тодорхойлолтыг ХБХ-тэй хамтран боловсруулж, МХГ, БСГ-ын даргаар батлуулсан байна.

СХХ-ийн дэргэдэх баталгаажуулалтын зөвлөлийн хурал 2014.03.02-ны өдөр хуралдаж, 19 үйлдвэрлэл, үйлчилгээний газрын тохирлын үнэлгээнд санал

хэлэлцэж, хүнсний аюулгүй байдлыг ханган ажиллах, хууль, журам мөрдөж ажиллах талаар зөвлөгөө өгч ажилласан байна.

2015 онд хүнсний үйлдвэрлэлийн салбарт хэрэгжүүлэх ажлыг төлөвлөж, Үр дүнгийн гэрээг боловсруулан, хэлтсийн даргад өгсөн байна.

Мал эмнэлгийн салбар:

Хаврын мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээний бэлтгэл ажлыг хангах ажлын хүрээнд шаардлагатай байгаа эм вакциныг татаж авах талаар Биокомбинат төрийн өмчийн үйлдвэрийн газартай тохиролцож хуваарийн дагуу эхний эм тарилгыг татан авах ажлыг зохион байгуулж байна. Одоогийн байдлаар шөвөг яр, галзуугийн вакциныг татан аваад байна. Орон нутагт ажил үйлчилгээ явуулж байгаа хувийн нэгжүүдийн хариуцах малчин болон малтай өрхүүдийн судалгааг шинэчлэн гаргаж сумдын Засаг дарга нараар батлуулан нэгэтгэж байна. Хаврын урьдчилан сэргийлэх арга хэмжээ эхлэж байгаатай холбогдуулан орон нутгийн Мал эмнэлгийн нэгжүүдийн урьдчилгаа санхүүжилт авах талаар ирүүлсэн хүсэлтийг хүлээн авч төрийн санд уламжлаад байна.

2016 оны мал эмнэлгийн арга хэмжээнд хамрагдах малын тоо, толгой түүнд шаардагдах эм бэлдмэлийн захиалгын төслийг боловсруулж бэлэн болгосон байна. 2015 оны вакцин тарилга захиалгын дагуу бүрэн ирхээр байгаа ч орон нутгаас олгодог үйлчилгээний хөлсний санхүүжилт нэмэгдээгүй 90,1 сая төгрөгөөр батлагдсан нь хүндрэлтэй байн

БАТЛАВ: ГАЗРЫН ДАРГА...../Ц.ЭНХЖАРГАЛ /

ҮЙЛДВЭР, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН
2015 ОНЫ 04 ДУГААР САРД ЗОХИОН БАЙГУУЛАХ
АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Д/д	Хийгдэх ажил	Огноо	Хариуцах эзэн	Хүрэх үр дүн
Мал аж ахуйн хэлтэс				
1.	Төлийн мэдээ, том малын хорогдлын мэдээг авч нэгтгэх	Сардаа	С.Баасан	Тайланг үнэн зөв гаргасан байна.
2.	Хишиг өдөр арга хэмжээ зохион байгуулах	Сардаа	МААХ	Орхон сумын МЭҮТ-тай хамтран зохион байгуулна.
3.	Ингэ хээлтүүлгийн мэдээ авах	Сардаа	С.Баасан	Сумдаас захиалга авч нэгтгэсэн байна.
4	Үржилд худалдан авах малын захиалга авах	Сардаа	МААХ	Сумдаас захиалга авч нэгтгэсэн байна
5	Мал ээмэгжүүлэлт бүртгэлжүүлэлтийн мэдээ авах	Сардаа	МААХ	Сумдаас захиалга авч нэгтгэсэн байна
Мал эмнэлгийн хэлтэс				
4.	Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх тарилганд шаардагдах вакцин тарилгыг хуваарийн дагуу татан авах	Сардаа	Х.Хавсамет	Эм, тарилгыг татан авсан байна.
5.	Орон нутгийн хувийн МЭ-ийн нэгжүүдэд олгох эм, тарилгын хуваарийг газрын даргаар батлуулж нэгжүүдэд олгох	Сардаа	Х.Хавсамет	Хуваарь гарч нэгжүүдэд тарилга олгосон байна.
6.	04-р сарын 15-наас эмчлэн сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах	Сардаа	Х.Хавсамет	Урьдчилан сэргийлэх арга хэмжээ эхэлсэн байна.
7.	Урьдчилан сэргийлэх арга хэмжээ зохион байгуулах тухай аймгийн Засаг даргын захирамж гаргуулах	Сардаа	Х.Хавсамет	Захирамж гарсан байна.
8.	МЭҮТасаг болон анхан шатны нэгжүүдийн захирал эзэдийг цуглуулж урьдчилан сэргийлэх арга	Сардаа	Х.Хавсамет Баасансүрэн	Мэргэжил арга зүйгээр хангагдсан

	хэмжээг зохион байгуулах талаар мэргэжил арга зүйн удирдлагаар хангах			байна
9.	Мал эмнэлгийн тасаг, нэгжүүдтэй үр дүнгийн гэрээ байгуулах	Сардаа	Х.Хавсамет	Гэрээ байгуулсан байна.
Хүнс, газар тариалангийн хэлтэс				
10.	Хэлтсийн сарын ажлын төлөвлөгөө тайланг батлуулах	4-р сарын 20	О.Нэмэхбат	Сарын төлөвлөгөөг батлуулсан.
11.	Тариаланчдын зөвлөгөөнийг зохион байгуулна	4-р сарын 10	О.Нэмэхбат	Зөвөлгөөн зохион байгуулагдсан байна
12.	Газар тариалангийн үйлдвэрлэлийн тариалалт, уринш боловсруулалтын техник засварын мэдээг гаргах	4-р сарын 5-ны дотор	О.Нэмэхбат	Хугацаанд нь мэдээлсэн байна
13.	Албан бичгүүдийг хариуг хугацаанд нь чанартай гаргаж холбогдох газарт хүргүүлэх	4-р сард	О.Нэмэхбат Г.Тунгалаг	Албан бичгүүдийн хариуг хугацаанд хүргэсэн байна.
14.	Гурилын үйлдвэрээс “Улаанбуудайн үлдэгдэл, гурил үйлдвэрлэлт, борлуулалтын үнийн судалгаа” гаргаж, ХХААЯ-д мэдээлэх	4-р сарын 31	Г.Тунгалаг	Албан тоотын хариуг хугацаанд нь гаргаж, мэдээг хүргэсэн байна.
15.	Жишсэн дундаж хүн амын гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг сар, улирал бүрээр тооцох	4-р сар	Г.Тунгалаг	Хэрэгцээт бүтээгдэхүүний тооцсон байна.
16.	Салбарын мэдээлэл хийх, хууль сурталчлах, зохистой дадал нэвтрүүлэх сургалт зохион байгуулах	4-р сар	Г.Тунгалаг	Хууль эрх зүйн мэдлэгийг олгосон байна.
17.	Хүнсний зах дээрх махны үнийн мэдээлэл гаргах	4-р сар	Г.Тунгалаг	Махны үнэ судалсан байна.
18.	Хүний нөөцийн нэмэлт ажлууд хийх	4-р сар	Г.Тунгалаг	

Төлөвлөгөөг нэгтгэсэн: Бичиг хэрэг, архивын эрхлэгч Э.Мөнх-Эрдэнэ

Төлөвлөгөөг хянасан: ЗУХэлтсийн дарга Б.Бат-Эрдэнэ